



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 1/23

Улаанбаатар хот

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн
улсын үзлэг, тооллогын дүнгээр авч
хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 195/260 дугаар хамтарсан тушаалаар "Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолын 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын дүнгээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 481 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл), Хууль эрх зүйн хэлтсийн дарга Д.Дэлгэрмаа, аймгийн Орон нутгийн өмчийн газар, Нийслэлийн өмчийн харилцааны газрын дарга нарт тус даалгах нь:

2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогоор илэрсэн санхүүгийн тайлан, бүртгэлд тусгагдаагүй төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг санхүүгийн тайланд тусгуулах;

2.2. Төрийн болон орон нутгийн өмчийн дутагдсан эд хөрөнгийн хариуцагчийг тогтоон хариуцлага тооцох, хохирол барагдуулах ажлыг зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэх;

2.3. Төрийн болон орон нутгийн өмчийн маргаантай эд хөрөнгийн жагсаалтыг нарийвчлан судалж, холбогдох хуулийн этгээдтэй хамтран хариуцагчийг тогтоох, маргааныг шийдвэрлүүлэх, шаардлагатай тохиолдолд хууль хяналтын байгууллагад хандах хүртэл арга хэмжээ авах;

2.4. Улсын үзлэг тооллогын үр дүнд бий болсон мэдээ, мэдээллийг төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, мэдээллийн цахим сангийн программ хангамжид бүрэн оруулах ажлыг зохион байгуулах;

2.5. Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн эд хөрөнгийн дотоодын тооллогыг нэгдсэн удирдамжаар хангах, хөрөнгийн бүртгэл хариуцсан ажилтнуудыг чадваржуулах, мэдээллийн сангийн программ хангамжийг ашиглахтай холбогдсон сургалт зохион байгуулах;

2.6.Төрийн болон орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийн бүртгэл, хөдлөл, өөрчлөлтийн дүн мэдээг төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн албатай хамтран нэгдсэн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулж байх;


2.7.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан хэрэгцээний үйлчилгээний автомашины тоо, төрлийг тогтоож, зардлыг бууруулах арга хэмжээ авч ажиллах;

2.8.Тооллогын дүнгээр илэрсэн илүүдэлтэй, ашиглалтгүй хөрөнгийг худалдах, акталж данснаас хасах, шилжүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;

2.9.Дээр дурдсан арга хэмжээг 2023 оны 3 дугаар улиралд багтаан зохион байгуулж дүнг нэгтгэн Засгийн газарт танилцуулах.

3. Төрийн болон орон нутгийн өмчийт хуулийн этгээдийн эзэмшилд байгаа эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, үр өгөөжийг нэмэгдүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл), Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ), Орон нутгийн өмчийн газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж, биелэлтийг 2023 оны 11 дүгээр сард багтаан танилцуулахыг Захиргаа удирдлагын хэлтэс (Н.Ганболд), Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл) нарт үүрэг болгосугай.



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
даргын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн
...A/23 дугаар тушаалын хавсралт

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай” 481 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

Д/д	Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний жагсаалт	Арга хэмжээний биелэлтийг дуусах хугацаа	Хариуцах этгээд	Хамтрах байгууллага	Хяналт тавих, нэгтгэх албан тушаалтан
1	Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн эрхийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэхтэй холбогдох журмын төсөл боловсруулах	2021-2024 онд	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс Хууль эрх зүйн хэлтэс	Хууль зүй, дотоод хэргийн яам	Д.Нарангэрэл Д.Тунгалагтуул
2	Төрийн болон орон нутгийн өмчийт хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг баталгаажуулах, цахим бүртгэлд хамруулах, газрыг үнэлж санхүүгийн тайланд тусгах ажлыг зохион байгуулах	2023 онд	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар Аймгийн орон нутгийн өмчийн газар	Газар зохион байгуулалт, геодези зурагзүйн газар	Д.Нарангэрэл Р.Ширчинням

			Нийслэлийн өмчийн харилцааны газар		
3	Төрийн болон орон нутгийн өмчит бүртгэлтэй автотээврийн хэрэгслийн бүртгэлийг улсын автотээврийн хэрэгслийн бүртгэлтэй тулган баталгаажуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах ажлыг зохион байгуулах	2023 онд багтаан	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар Аймгийн орон нутгийн өмчийн газар Нийслэлийн өмчийн харилцааны газар	“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ	Д.Наангэрэл Б.Мөнхбаатар
4	Төрийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах ажлын хэсэгт орж ажиллаж хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж ажиллах	Тухай бүр	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс Аймгийн орон нутгийн өмчийн газар Нийслэлийн өмчийн харилцааны газар	Холбогдох яам, агентлаг	Ц.Баяр-Эрдэнэ Д.Наангэрэл Хариуцсан мэргэжилтэн нар Орон нутгийн өмчийн газар
	Улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл,		Төрийн өмчийн бодлого,		

5	тусlamж болон гадаад зээлийн хөрөнгийн дамжуулан зээлдүүлэх зээлийн эх үүсвэрээс бий болсон хөрөнгийг хууль тогтоомж болон эрх бүхийн этгээдийн шийдвэрийн дагуу ашиглах, эзэмших төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчтэй хуулийн этгээдийн ашиглалтад хүлээн авч, данс бүртгүүлэх ажлыг зохион байгуулах	Байнга	зохицуулалтын газар Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс Аймгийн орон нутгийн өмчийн газар Нийслэлийн өмчийн харилцааны газар	Төсвийн ерөнхийлөн захирагч нар	Д.Наангэрэл Э.Дуламсүрэн
6	Концессын гэрээний дагуу төрийн өмчид шилжиж буй хөрөнгийг хүлээн авч тооцоо нийлэх, эзэмших, ашиглах хуулийн этгээд, байгууллагын данс бүртгэлд тусгуулах ажлыг тухай бүр хэрэгжүүлэх	Тухай бүр	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс Аймгийн орон нутгийн өмчийн газар	Эдийн засаг, хөгжлийн яам	Д.Наангэрэл П.Уранмандах

			Нийслэлийн өмчийн харилцааны газар		
7	Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн бүртгэлийг сайжруулах ажлыг зохион байгуулах	Байнга	Аймгийн орон нутгийн өмчийн газрууд Нийслэлийн өмчийн харилцааны газар	Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга	Д.Наангэрэл Д.Батболд
8	Үйл ажиллагаа нь доголдсон, зогсонги байдалд орсон, хувийн хэвшилтэй давхардсан үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн болон орон нутгийн өмчтэй хуулийн этгээд, үйлдвэрийн газрыг татан буулгах, өөрчлөн байгуулах зэргээр бүтцийн өөрчлөлт, хийх, хөрөнгийг шилжүүлэх, худалдах ажлыг зохион байгуулах	Тухай бүр	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс Аймгийн орон нутгийн өмчийн газар Нийслэлийн өмчийн харилцааны газар	Холбогдох яам, агентлаг	Д.Наангэрэл Б.Сүнжидмаа
	Улсын үзлэг, тооллогын дүнгээр дутагдсан хөрөнгийг нөхөн төлүүлэх, хэрэгцээнээс илүүдэлтэй болон цаашид ашиглах боломжгүй болсон		Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар		

9	хөрөнгийг шилжүүлэх, худалдах, устгах, өмчлөлийн талаар маргаантай байгаа хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг холбогдох яам, агентлагтай хамтран зохих журмын дагуу зохион байгуулах	2023 оны 9 дүгээ сард багтаан	Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс	Холбогдох яам, агентлаг	Д.Нарангэрэл М.Баярмаа
---	---	-------------------------------	--	-------------------------	---------------------------

---Оо---